*Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны ... сарын ...-ны ... дугаар тушаалын ... дугаар хавсралт*

**Тайлбар:**

- Шинэ-Зеландын дүрмийн өөрчлөлтөөр нэмж орсон / ~~хассан~~
- “ИНД-ийн нэр томьёоны тайлбар”-ын дагуу нэмж орсон / ~~хассан~~

**Анхаар:**
Та баруун дээд буланд байгаа navigation bar-ийн “**Two page view**”-г сонгож монгол, англи хувилбарыг зэрэгцүүлэн харж болно.




# ИНД - 12

## Осол, зөрчил болон статистик мэдээлэл

Иргэний нисэхийн ерөнхий газар

**Note:**

- NZCAR Part-12 revised items: revised / ~~deleted~~

**Attention:**
Please select "**Two page view**" option on the top-right navigation bar to view the Mongolian and English versions of the rule side by side.




# PART 12

## Accidents, Incidents, and Statistics Procedure

Civil Aviation Authority of Mongolia

## ДҮРМИЙН ТАЙЛБАР

ИНД-12 нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:

- осол, зөрчлийг мэдээлэх, шинжлэн шалгах ба тайлан гаргах;
- осол, эсхүл ноцтой зөрчлийн дараа агаарын хөлөг, түүнд агуулагдаж байгаа эд зүйл болон агаарын хөлгийн бүртгэлийг хамгаалалтад авах;
- агаарын хөлгийн үйл ажиллагаа, статистик тоо баримтын тайлан.

**Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-12-ын цахим хувилбар бөгөөд зөвхөн эшлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-12, түүний нэмэлт өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.**

## DESCRIPTION

Part 12 prescribes rules for the-

- notification, investigation, and reporting of accidents and incidents;
- preservation of aircraft, aircraft contents, and aircraft records following an accident or serious incident;
- reporting of aircraft operating and statistical data.

**This document is the current consolidated version of Part 12 produced by the Civil Aviation Authority, and serves as a reference only. It is compiled from the official ordinary rules that have been signed into law by the Minister of Road and Transport. Copies of the official rule and amendments as signed by Minister may be obtained from the Civil Aviation Authority or may be downloaded from the official web site at: [www.mcaa.gov.mn](http://www.mcaa.gov.mn)**

## Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн дүрмийг боловсруулсан.

| **Өөрчлөлтийн түүх** | **Хүчинтэй огноо** |
|---|---|
| **Анхны боловсруулалт** | 2001 оны 10 сарын 01 |
| Өөрчлөлт 1 | 2002 оны 09 сарын 17 |
| **Хоёрдугаар боловсруулалт** | 2010 оны 03 сарын 26 |
| **Гуравдугаар боловсруулалт** | 2019 оны 06 сарын 12 |
| Өөрчлөлт 3.1 | 2023 оны ... сарын ... |

**Тэмдэглэл:** ИНД-12-ын өөрчлөлт 3.1-ийг монгол, англи хэл дээр, NZ Part 12-ын 2020 оны 12 сарын 01-ний A.11-д үндэслэн боловсруулсан болно.

## Bulletin

ICAO 29th Assembly Resolution A29-3 of year 1992 urges States to promote global harmonization of national rules. In order to implement this Resolution, Mongolian Civil Aviation Regulation has been developed based on "Memorandum for Technical Cooperation" between CAA of Mongolia and New Zealand, signed on 6th of May, 1999.

| **Amendment history** | **Effective Date** |
|---|---|
| **Original issue** | 01 October 2001 |
| Amendment 1 | 17 September 2002 |
| **Second issue** | 26 March 2010 |
| **Third issue** | 12 June 2019 |
| Amendment 3.1 | … … 2023 |

**Note:** This Part 12 Amend.3.1 has been released in Mongolian and English languages, based on NZCAR Part 12 Amend.11 dated 01.Dec.2020.

## Гарчиг

**A Бүлэг - Ерөнхий зүйл ........ 1**
12.1. Зорилго ........ 1
12.3. Нэр томьёо ба товчлол ........ 1

**B Бүлэг - Хэрэг явдлыг мэдээлэх, шинжлэн шалгах ба тайлан гаргах ........ 1**
12.51. Ослыг мэдээлэх ........ 1
12.53. Ослын дэлгэрэнгүй мэдээлэл ........ 2
12.55. Зөрчлийг мэдээлэх ........ 2
12.57. Зөрчлийн дэлгэрэнгүй мэдээлэл ........ 4
12.59. Шинжлэн шалгах ажиллагаа болон тайлан ........ 4
12.61. Мэдээлэл өгсөн этгээдийг нууцлах ........ 5
12.63. Шийтгэлээс ангид байх ........ 5

**C Бүлэг - Агаарын хөлөг, түүний эд зүйл, бүртгэлийг хамгаалах ........ 5**
12.101. Осолд өртсөн агаарын хөлөгт нэвтрэх ........ 5
12.103. Бүртгэлийг хамгаалалтад авах ........ 6
12.105. Гэмтэлтэй бүтээгдэхүүн, бүрдэл хэсгийг хадгалах ........ 6

**D Бүлэг - Статистикийн мэдээлэл ........ 6**
12.151. Агаарын хөлгийн үйл ажиллагааны статистикийн мэдээлэл ........ 6
~~12.152. ХАА-н нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн статистик мэдээ (19.103)~~ ........ 8
12.153. Статистикийн тайлангийн нууцлал ........ 9

**Хавсралт A - Зөрчлийн анхны мэдээлэлд шаардлагатай мэдээлэл ........ 10**

# List of Rules


**Subpart A - General ... 1**
12.1. Purpose ... 1
12.3. Definitions and abbreviations ... 1

**Subpart B - Notification, Investigation, and Reporting of Occurrences ... 1**
12.51. Notification of accident ... 1
12.53. Details of accident ... 2
12.55. Notification of incident ... 2
12.57. Details of incident ... 4
12.59. Investigation and reporting ... 4
12.61. Confidentiality of persons submitting information ... 5
12.63. Non-prosecution ... 5

**Subpart C - Preservation of Aircraft, its Contents, and Records ... 5**
12.101. Access to aircraft involved in an accident ... 5
12.103. Preservation of records ... 6
12.105. Retention of defective products and components ... 6

**Subpart D - Statistics ... 6**
12.151. Aircraft operating statistics ... 6
~~12.152. Agricultural operators - statistical returns (19.103)~~ ... 8
12.153. Confidentiality of statistical reports ... 9

**Appendix A - Information Required for Initial Notification of Incidents ... 10**

# А Бүлэг - Ерөнхий зүйл

## 12.1. Зорилго

(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, энэ Дүрэм нь дараах шаардлагыг тогтооно:

(1) осол, зөрчлийг~~н талаар~~ мэдээлэх, шинжлэн шалгах ба тайлан гаргах;

(2) осол, эсхүл ноцтой зөрчлийн дараа агаарын хөлөг, агаарын хөлөгт агуулагдсан эд зүйл болон агаарын хөлгийн бүртгэлийг хамгаалалтад авах;

(3) осол, байгууламжийн доголдлын зөрчил, агаарын зайн зөрчил, эсхүл түгээгдсэн мэдээллийн зөрчилтэй холбоотой бүртгэлийг хамгаалалтад авах;

(4) агаарын хөлгийн үйл ажиллагаа, статистик тоо баримтын тайлан гаргах.

(b) Энэ Дүрэм нь, Хууль болон ИНД-115-ын дагуу Даргын олгосон Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнээс гадуур хийгддэг дараах үйл ажиллагаатай холбоотой зөрчилд хамаарахгүй:

(1) ИНД-101, ИНД-102-ын дагуу гүйцэтгэж байгаа жиро-глайдер, парасэйл, хүнгүй агаарын хөлөг, цаасан шувуу болон пуужингийн үйл ажиллагаа;

(2) ИНД-103-ын дагуу гүйцэтгэж байгаа хэт хөнгөн агаарын хөлгийн үйл ажиллагаа;

(3) ИНД-104-ийн дагуу гүйцэтгэж байгаа глайдерын үйл ажиллагаа;

(4) ИНД-105-ын дагуу гүйцэтгэж байгаа шүхрийн үйл ажиллагаа;

(5) ИНД-106-гийн дагуу гүйцэтгэж байгаа ханг-глайдерын үйл ажиллагаа.

## 12.3. Нэр томьёо ба товчлол

Энэ Дүрэмтэй холбоотой нэр томьёо болон товчлол нь ИНД-ийн нэр томьёоны тайлбарт багтсан.

# B Бүлэг - Хэрэг явдлыг мэдээлэх, шинжлэн шалгах ба тайлан гаргах

## 12.51. Ослыг мэдээлэх

(a) Осолд өртсөн агаарын хөлгийн дарга, эсхүл хэрэв агаарын хөлгийн дарга амь насаа алдсан, эсхүл хүнд гэмтсэн, эсхүл агаарын хөлөг алга болсон тохиолдолд, тухайн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн ослыг~~н талаар АХОШШБ болон~~ ИНЕГ-т цаг алдалгүй ~~мэдээлнэ~~ мэдэгдэх үүрэгтэй.

(b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу ирүүлэх мэдээлэл нь ИНЕГ-ын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр байх ба боломжтой бол дараах мэдээллийг агуулсан байна:

(1) осол болсон өдөр, цаг;

(2) ослын шинж байдал;

(3) агаарын хөлгийн маяг, үндэсний харьяалал болон бүртгэлийн дугаар;

(4) агаарын хөлгийн өмчлөгч болон үйл ажиллагаа эрхлэгчийн нэр;

(5) хялбар тодорхойлогдох газарзүйн цэгээр илэрхийлсэн агаарын хөлгийн байршил, эсхүл хамгийн сүүлд мэдэгдэж байсан байршлын мэдээлэл;

# Subpart A - General

## 12.1. Purpose

(a) Subject to paragraph (b), this Part prescribes rules for the-

(1) notification, investigation, and reporting of accidents and incidents; and

(2) preservation of aircraft, aircraft contents, and aircraft records following an accident or serious incident; and

(3) preservation of records relating to an accident, facility malfunction incident, an airspace incident, or a promulgated information incident; and

(4) reporting of aircraft operating and statistical data.

(b) This Part does not apply to an incident that is associated with any of the following operations that are not conducted under the authority of an adventure aviation operator certificate issued by the Director under the Act and Part 115:

(1) gyrogliders and parasails, unmanned aircraft, kites, and rockets operated under Parts 101 and 102:

(2) microlight aircraft operated under Part 103:

(3) gliders operated under Part 104:

(4) parachutes operated under Part 105:

(5) hang gliders operated under Part 106.

## 12.3. Definitions and abbreviations

Definitions and abbreviations relating to this Part are contained in CAR interpretation summary.

# Subpart B - Notification, Investigation, and Reporting of Occurrences

## 12.51. Notification of accident

(a) Each pilot-in-command of an aircraft that is involved in an accident or, if that person is fatally or seriously injured, or if the aircraft is missing, the operator, ~~shall~~ must notify the ~~AAIB and~~ Authority of the accident as soon as practicable.

(b) The notification under paragraph (a) shall be in a manner acceptable to the Authority and contain, where ascertainable, the-

(1) date and time of the accident; and

(2) nature of the accident; and

(3) type, nationality, and registration marks of the aircraft; and

(4) names of the aircraft owner and operator; and

(5) position or last known position of the aircraft with reference to an easily defined geographical point; and

(6) агаарын хөлгийн даргын нэр;
(7) үйл ажиллагааны төрөл;
(8) агаарын хөлгийн нисэн гарсан сүүлчийн цэг;
(9) агаарын хөлөг буулт үйлдэхээр төлөвлөсөн дараагийн цэг;
(10) тэнгэрийн байдал, хур тунадас, салхины хурд болон ~~алсын бараны харагдцын~~ харааны тодорхойлолт;
(11) агаарын хөлгийн бүхээгт байсан хүний тоо;
(12) ослын улмаас амь насаа алдсан, эсхүл хүндээр гэмтсэн зорчигч болон багийн гишүүний тоо;
(13) ослын улмаас амь насаа алдсан, эсхүл хүндээр гэмтсэн, зорчигч, эсхүл багийн гишүүнээс бусад хүмүүсийн тоо;
(14) агаарын хөлгийн гэмтлийн дэлгэрэнгүй мэдээлэл.

## 12.53. Ослын дэлгэрэнгүй мэдээлэл

(a) Осолд өртсөн агаарын хөлгийн дарга, эсхүл хэрэв агаарын хөлгийн дарга амь насаа алдсан, эсхүл хүнд гэмтсэн тохиолдолд, үйл ажиллагаа эрхлэгч нь CA005 маягтад шаардсан ослын дэлгэрэнгүй мэдээллийг осол гарснаас хойш 10 хоногийн дотор ~~АХОШШБ болон~~ ИНЕГ-т дараах хэлбэрээр хүргүүлнэ:

(1) CA005 маягтаар; эсхүл
(2) ИНЕГ-ын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр.

(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан дэлгэрэнгүй мэдээлэл нь осол гарсан цаг үед агаарын хөлөгт байсан нисэх багийн гишүүн бүрийн тухайн осолтой холбоотой бодит байдал, нөхцөл болон нөхцөл байдлыг дэлгэрэнгүй дурдсан тайлбарыг агуулна.

(c) Хэрэв нисэх багийн гишүүн эрүүл мэндийн шалтгаанаар энэ зүйлийн (b)-д шаардсан тайлбарыг гаргаж өгөх боломжгүй бол боломжтой болсон даруйд нөхөн гаргаж өгнө.

## 12.55. Зөрчлийг мэдээлэх

(a) Хууль болон дараах Дүрмийн дагуу Даргаас олгосон гэрчилгээ эзэмшигч нь, хэрэв ноцтой зөрчил, эсхүл агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй байдалд шууд аюул учруулах зөрчил~~, эсхүл ноцтой зөрчил~~д өртсөн бол ~~холбогдох~~ тухайн зөрчлийг ИНЕГ-т цаг алдалгүй ~~мэдээлэх~~ мэдэгдэх үүрэгтэй:

(1) ИНД-115, 119, 129 болон 137 - агаарын хөлгийн зөрчил, эсхүл аюултай барааны зөрчлийг;
(2) ИНД-172 - агаарын зайн зөрчлийг;
(3) ИНД-171, 174 - байгууламжийн доголдлын зөрчлийг;
(4) ИНД-47, 115, 119, 129, 137, 145, 146 болон 148 - гэмтлийн зөрчлийг;
(5) ИНД-119, 129, 139, 140, 171 болон 172 - аюулгүйн хамгаалалтын зөрчлийг;
(6) ИНД-139 - аэродромын зөрчлийг;
(7) ИНД-139, 171, 173, 174 болон 175 - түгээгдсэн мэдээллийн зөрчлийг;
(8) ИНД-119, 129 болон 109 - ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчлийг.

(6) name of the pilot-in-command of the aircraft; and
(7) type of operation; and
(8) last point of departure of the aircraft; and
(9) next point of intended landing of the aircraft; and
(10) description of the sky condition, precipitation, wind velocity, and visibility; and
(11) number of persons on board the aircraft; and
(12) number of crew and passengers killed or seriously injured as a result of the accident; and
(13) number of persons killed or seriously injured as a result of the accident that were not crew or passengers; and
(14) details of damage to the aircraft.

## 12.53. Details of accident

(a) The pilot-in-command of an aircraft that is involved in an accident or, if that person is fatally or seriously injured, the operator, shall provide the occurrence details requested on form CA005 to the ~~AAIB and~~ Authority within 10 days of the accident-
(1) on form CA005; or
(2) by a means acceptable to the Authority.

(b) The details required by paragraph (a) shall include a statement by each flight crew member who was on the aircraft at the time of the accident, detailing the facts, conditions, and circumstances relating to the accident.

(c) Where a flight crew member is incapacitated, the statement required by paragraph (b) shall be submitted as soon as the flight crew member is able.

## 12.55. Notification of incident

(a) A holder of a certificate issued by the Director under the Act and the following Parts must notify the Authority as soon as practicable of any associated incident if the certificate holder is involved in the incident and the incident is a serious incident or is an immediate hazard to the safety of an aircraft operation:
(1) Parts 115, 119, 129 and 137 - aircraft incident, or dangerous goods incident:
(2) Part 172 - airspace incident:
(3) Parts 171 and 174 - facility malfunction incident:
(4) Parts 47, 115, 119, 129, 137, 145, 146, and 148 - defect incident:
(5) Parts 119, 129, 139, 140, 171, and 172 - security incident:
(6) Part 139 - aerodrome incident:
(7) Parts 139, 171, 173, 174, and 175 - promulgated information incident:
(8) Parts 119, 129, and 109 - cargo security incident.

(b) Ноцтой зөрчил, эсхүл агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй байдалд шууд аюул учруулах зөрчил~~, эсхүл ноцтой зөрчил~~д өртсөн этгээд нь тухайн зөрчлийг~~н талаар~~ ИНЕГ-т цаг алдалгүй ~~мэдээлэх~~ мэдэгдэх үүрэгтэй, хэрэв тухайн этгээд нь:

(1) агаарын хөлөг, нисэхийн бүтээгдэхүүн, эсхүл нисэхтэй холбоотой үйлчилгээний хувьд, үйл ажиллагаа эрхэлдэг, техник үйлчилгээ хийдэг, үйлчилгээ үзүүлдэг, эсхүл бусад хэлбэрээр оролцдог бол;

(2) энэ зүйлийн (a)-д дурдсан гэрчилгээ эзэмшигчийн ажилтан биш, эсхүл түүнд хамааралгүй бол; эсхүл

(3) ИНД-95-ын дагуу үүрэг хариуцлага хүлээсэн бол.

(c) ~~Хэрэв~~ Агаарын зайн зөрчил, эсхүл шувуутай холбоотой зөрчилд өртсөн агаарын хөлгийн дарга хэрэв тухайн зөрчил нь ноцтой зөрчил, эсхүл агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй байдалд шууд аюул учруулах зөрчил бол ~~агаарын хөлгийн дарга~~ зөрчлийг~~н талаар~~ ИНЕГ-т цаг алдалгүй ~~мэдээлэх~~ мэдэгдэх үүрэгтэй.

(d) Энэ зүйлийн (a), (b), (c) болон (d)-д шаардсан зөрчлийн мэдээллийг ИНЕГ-ын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр ирүүлэх үүрэгтэй ба тодруулах боломжтой бол дараах хавсралтад заасан мэдээллийг агуулсан байна:

(1) агаарын зайн зөрчлийн хувьд, Хавсралт A(a);

(2) гэмтлийн зөрчлийн хувьд, Хавсралт A(b);

(3) байгууламжийн доголдлын зөрчлийн хувьд, Хавсралт A(c);

(4) агаарын хөлгийн зөрчлийн хувьд, Хавсралт A(d);

(5) аюулгүйн хамгаалалтын зөрчлийн хувьд, Хавсралт A(e);

(6) түгээгдсэн мэдээллийн зөрчлийн хувьд, Хавсралт A(f);

(7) аэродромын зөрчлийн хувьд, Хавсралт A(g);

(8) ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчлийн хувьд, Хавсралт A(h);

(9) аюултай барааны зөрчил, шувуутай холбоотой зөрчил, эсхүл бусад зөрчлийн хувьд, Хавсралт A(i).

(e) Энэ зүйлийн (a)-г үл харгалзан:

(1) Хууль болон ИНД-119-ийн дагуу Даргын олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч, хэрэв зөрчил нь EDTO нислэгт ашиглаж байгаа, эсхүл ашигладаг агаарын хөлөгтэй холбоотой гарсан ба тухайн зөрчилд дараах нөхцөл байдал холбоотой бол зөрчил гарснаас хойш 72 цагийн дотор тухайн зөрчлийг~~н талаар~~ ИНЕГ-т ~~мэдээлэх~~ мэдэгдэх үүрэгтэй:

(i) нислэгт татах хүчний төхөөрөмж ~~агаарт~~ унтрах; эсхүл

(ii) даялалт (diversion), эсхүл буцах эргэлт (a turn back) үйлдэх үед; эсхүл

(iii) нислэгт гэнэт түлш алдагдах, эсхүл түлшгүй болох, эсхүл залруулах боломжгүйгээр түлшний тэнцвэр алдагдах; эсхүл

(iv) EDTO нислэгт нөлөөлөх системийн доголдол; эсхүл

(v) EDTO нислэгийн аюулгүй байдалд нөлөөлөх бусад хэрэг явдал;

(b) A person who is involved in an incident that is a serious incident or an immediate hazard to the safety of an aircraft operation must notify the Authority of the incident as soon as practicable if the person-

(1) operates, maintains, services, or does any other act in respect of an aircraft, aeronautical product, or aviation related service; and

(2) is not employed by, or associated with, the holder of a certificate referred to in paragraph (a); or

(3) has responsibilities under Part 95.

(c) A pilot-in-command of an aircraft that is involved in an airspace incident or a bird incident must notify the Authority of the incident as soon as practicable if the incident is a serious incident or an immediate hazard to the safety of an aircraft operation.

(d) The notification of an incident required by paragraphs (a), (b), (c) and (e) must be conveyed by a means acceptable to the Authority and contain, where ascertainable, information in accordance with the following:

(1) for an airspace incident, Appendix A(a):

(2) for a defect incident, Appendix A(b):

(3) for a facility malfunction incident, Appendix A(c):

(4) for an aircraft incident, Appendix A(d):

(5) for a security incident, Appendix A(e):

(6) for a promulgated information incident, Appendix A(f):

(7) for an aerodrome incident, Appendix A(g):

(8) for a cargo security incident, Appendix A(h):

(9) for a dangerous goods incident, bird incident, or any other incident, Appendix A(i).

(e) Despite paragraph (a), a holder of-

(1) an AOC issued by the Director under the Act and Part 119 must notify the Authority of an aircraft incident or a defect incident within 72 hours of the incident occurring if the incident is associated with an aircraft that is performing or is used to perform an EDTO and the incident involves-

(i) an in-flight shutdown of a propulsion system; or

(ii) a diversion or a turn back; or

(iii) an in-flight, inadvertent fuel loss or unavailability of fuel or an un-correctable fuel imbalance; or

(iv) a malfunction of an EDTO significant system; or

(v) any other occurrence which affects the safety of an EDTO; and

(2) хэрэв EDTO нислэгт ашигладаг агаарын хөлөгтэй холбоотой дараах зөрчил гарсан бол Хууль болон ИНД-145-ын дагуу олгосон техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигч нь гэмтлийн зөрчлийг 72 цагийн дотор ИНЕГ-т ~~мэдээлэх~~ мэдэгдэх үүрэгтэй:
   (i) EDTO нислэгт нөлөөлөх системийн доголдолтой холбоотой зөрчил; эсхүл
   (ii) EDTO нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлгийн аюулгүй байдалд нөлөөлөх бусад гэмтэл.

## 12.57. Зөрчлийн дэлгэрэнгүй мэдээлэл

(a) Ноцтой зөрчил, эсхүл агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй байдалд шууд аюул учруулах зөрч~~и~~лийг~~, эсхүл ноцтой зөрчлийн талаар~~ 12.55-д заасны дагуу мэдээлснийг үл харгалзан, тухайн зөрчилд өртсөн ~~тэй холбоотой~~ дараах этгээд нь зөрчлийн дэлгэрэнгүй мэдээллийг (b)(1), эсхүл (b)(2)-т заасан холбогдох маягтад шаардсаны дагуу ИНЕГ-т хүргүүлэх үүрэгтэй:

(1) 12.55(a)-д дурдсан гэрчилгээ эзэмшигч;

(2) 12.55(b)-д дурдсан этгээд;

(3) 12.55(c)-д дурдсан хөлгийн дарга.

(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан этгээд нь зөрчлийн дэлгэрэнгүй мэдээллийг тухайн зөрчил гарснаас хойш 14 хоногийн дотор ИНЕГ-т дараах хэлбэрээр хүргүүлэх үүрэгтэй:

(1) CA005 маягтаар; эсхүл

(2) гэмтлийн зөрчлийг CA005D маягтаар; эсхүл

(3) ИНЕГ-ын хүлээн зөвшөөрөхүйц бусад хэлбэрээр.

## 12.59. Шинжлэн шалгах ажиллагаа болон тайлан

Энэ дүрмийн 12.57-д заасны дагуу ИНЕГ-т зөрчлийн дэлгэрэнгүй мэдээллийг хүргүүлэх шаардлагатай 12.55(a)-д дурдсан гэрчилгээ эзэмшигч нь, ИНЕГ-аас өөрөөр мэдэгдээгүй бол ~~сэнээс бусад тохиолдолд~~ дараах үүрэгтэй:

(1) тухайн зөрчилтэй холбоотой бодит байдлыг тодорхойлох, бодит байдлын хүрээнд зөрчлийн шалтгаан, эсхүл шалтгаануудыг тогтоох зорилгоор шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэх;

(2) тухайн зөрчил гарснаас хойш 90 хоногийн дотор шинжлэн шалгах ажиллагааг дуусган, тайланг ИНЕГ-т дараах хэлбэрээр хүргүүлэх:
   (i) CA005 маягтаар; эсхүл
   (ii) гэмтлийн зөрчлийг CA005D маягтаар; эсхүл
   (iii) ИНЕГ-ын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр;

(3) ижил төстэй зөрчил давтагдахаас сэргийлэх зорилгоор авсан арга хэмжээг~~ний талаар~~ ИНЕГ-т мэдээлэх.

(2) an aircraft maintenance organisation certificate issued under the Act and in accordance with Part 145 must notify the Authority of a defect incident within 72 hours of the incident occurring if the incident is associated with an aircraft that is used to perform an EDTO and-

(i) the incident involves a malfunction of an EDTO significant system; or

(ii) any other defect that could affect the safety of an aircraft performing an EDTO.

## 12.57. Details of incident

(a) Notwithstanding the notification of a serious incident or an immediate hazard to the safety of an aircraft operation under rule 12.55, the following persons who are involved in an incident must provide the Authority with the applicable details of the incident in accordance with information requested on the applicable form specified in paragraph (b)(1) or (b)(2):

(1) a holder of a certificate referred to in rule 12.55(a):

(2) a person referred to in rule 12.55(b):

(3) a pilot-in-command referred to in rule 12.55(c).

(b) A person who is required under paragraph (a) to provide the Authority with details of an incident must provide those details within 14 days of the incident-

(1) on form CA005; or

(2) on form CA005D for a defect incident; or

(3) by another means that is acceptable to the Authority.

## 12.59. Investigation and reporting

A holder of a certificate referred to in rule 12.55(a) who is required to provide details of an incident to the Authority under rule 12.57 must, unless otherwise notified by the Authority,-

(1) conduct an investigation to identify the facts relating to its involvement in the incident and establish, so far as those facts allow, the cause or causes of the incident; and

(2) on completion of the investigation, submit a report of the investigation to the Authority no later than 90 days after the incident-

(i) on form CA005; or

(ii) on form CA005D for a defect incident; or

(iii) by a means acceptable to the Authority; and

(3) advise the Authority of any actions taken to prevent recurrence of a similar incident.

### 12.61. Мэдээлэл өгсөн этгээдийг нууцлах

Энэ дүрмийн 12.55, эсхүл 12.57-д заасны дагуу мэдээлэл өгсөн этгээд нь нууцлахыг хүссэн тохиолдолд, ~~АХОШШБ болон~~ ИНЕГ нь:

(1) эх үүсвэрийг таньж тогтоож болох мэдээллийг цаг алдалгүй арилгана;

(2) энэ зүйлийн (1)-ийн дагуу арилгасан мэдээллийг өөр аль ч бүртгэлд тэмдэглэхгүй.

### 12.63. Шийтгэлээс ангид байх

~~АХОШШБ болон~~ ИНЕГ нь дараахаас бусад тохиолдолд, аливаа этгээдийн энэ дүрмийн дагуу өгсөн мэдээллийг мөрдөн шалгах, эсхүл хариуцлага тооцох зорилгоор ашиглахгүй, эсхүл ашиглах боломж олгохгүй:

(1) тухайн мэдээлэл нь хүн, эсхүл өмч хөрөнгөд хэрэгцээ шаардлагагүйгээр аюул учруулсан үйлдэл, эсхүл эс үйлдлийг илчилсэн бол; эсхүл

(2) хуурамч мэдээлэл өгсөн бол; эсхүл

(3) ~~АХОШШБ болон~~ ИНЕГ нь мэдээллийг хуулийн дагуу, эсхүл шүүхийн шийдвэрийн дагуу гаргаж өгөх үүрэг хүлээсэн бол.

## C Бүлэг - Агаарын хөлөг, түүний эд зүйл, бүртгэлийг хамгаалах

### 12.101. Осолд өртсөн агаарын хөлөгт нэвтрэх

(a) Хууль болон энэ зүйлийн (b), (c)-д зааснаас бусад тохиолдолд, АХОШШБ-аас тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрөөгүй бол аливаа этгээд нь осолд өртсөн агаарын хөлөг, эсхүл түүнд агуулагдсан эд зүйлд нэвтрэх, оролдох, эсхүл салгаж авч болохгүй.

(b) Хуульд заасан хязгаарлалтыг харгалзан, АХОШШБ нь шинжлэн шалгах зорилгоор, осолд өртсөн агаарын хөлөг, эсхүл түүнд агуулагдсан эд зүйлд нэвтрэх, үзлэг шалгалт хийх, хамгаалах, эсхүл салгаж авч болно.

(c) Энэ зүйлийн (d)-г харгалзан, этгээд нь:

(1) хүмүүс, эсхүл мал амьтныг тухайн агаарын хөлөг, эсхүл эвдэрхий хэсгийн дотроос гаргана; эсхүл

(2) агаарын хөлөг, эвдэрхий хэсэг, эсхүл түүнд агуулагдсан ачаа, эсхүл шууданг цаашдын гэмтлээс хамгаална; эсхүл

(3) бүхээгийн дуу чимээ бичигч (CVR), нислэгийн өгөгдөл бичигч (FDR), эсхүл ослын байрлал дамжуулагчийг унтраах, эсхүл салгана; эсхүл

(4) боломжит өөр арга зам байхгүй тохиолдолд, олон нийтэд, эсхүл нислэгийн хөдөлгөөнд саад учруулахаас сэргийлнэ.

(d) Энэ зүйлийн (c)-д заасны дагуу салгаж авсан агаарын хөлгийн эвдэрхий хэсэг, шуудан, эсхүл ачааг:

(1) зөвхөн тэдгээрийн аюулгүй байдлыг бататгах шаардлагатай зайд шилжүүлнэ;

(2) тухайн агаарын хөлгийн аль хэсгээс авсныг үзүүлэх боломжтойгоор, тусдаа талбайд хадгална;

### 12.61. Confidentiality of persons submitting information

The ~~AAIB and~~ Authority shall, when confidentiality is requested by a person submitting information under 12.55 or 12.57-

(1) as soon as practicable, remove any information that might reveal the identity of the source; and

(2) not make any other record of the information removed under subparagraph (1).

### 12.63. Non-prosecution

The ~~AAIB and~~ Authority shall not use or make available for the purpose of prosecution investigation or for prosecution action any information submitted to it by a person under this Part unless-

(1) the information reveals an act or omission that caused unnecessary danger to any other person or to any property; or

(2) false information is submitted; or

(3) the ~~AAIB and~~ Authority is obliged to release the information pursuant to a statutory requirement or by order of a Court.

## Subpart C - Preservation of Aircraft, its Contents, and Records

### 12.101. Access to aircraft involved in an accident

(a) Except as provided in the Act, and paragraphs (b) and (c), no person shall access, interfere with, or remove, an aircraft or its contents that is involved in an accident unless authorised to do so by the AAIB.

(b) Subject to the limitations contained in the Act, the AAIB may, for the purpose of its investigation, access, inspect, secure, or remove, an aircraft or its contents that is involved in an accident.

(c) A person may, subject to paragraph (d)-

(1) remove persons or livestock from the aircraft or wreckage; or

(2) protect the aircraft, wreckage, or contents, including mail or cargo, from further damage; or

(3) disconnect or deactivate any cockpit voice recorder, flight data recorder, or emergency location transmitter; or

(4) prevent obstruction to the public or to air navigation where no practical alternative is available.

(d) Any aircraft wreckage, mail, or cargo removed under paragraph (c) shall-

(1) be moved only so far as necessary to ensure its safety; and

(2) be kept in separate distinct areas to indicate from which part in the aircraft it has been taken; and

(3) боломжтой бол тэдгээрийн анхны байрлал, мөргөлтийн чухал ул мөрийг гэрэл зураг, гар зураг, эсхүл тэмдэглэлээр баримтжуулна.

### 12.103. Бүртгэлийг хамгаалалтад авах

(a) Ноцтой зөрчил, эсхүл осолд өртсөн агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн агаарын хөлгийн үйл ажиллагаа болон техник үйлчилгээтэй холбоотой бүх мэдээллийг агуулсан бичлэгийн төхөөрөмжийг багтаасан бүртгэлийг ~~АХОШШБ болон~~ ИНЕГ-аас өөрөөр мэдэгдээгүй бол осол, эсхүл ноцтой зөрчил гарснаас хойш 14 хоногоос доошгүй хугацаагаар битүүмжлэн хадгалах үүрэгтэй.

(b) Зөрчил, эсхүл осолд холбогдсон, дараах Дүрмийн дагуу олгосон гэрчилгээ эзэмшигч нь, ~~АХОШШБ болон~~ ИНЕГ-аас өөрөөр мэдэгдээгүй бол осол, эсхүл зөрчилтэй холбоотой бүртгэлийн дэвтэрт оруулсан бичилт, цахим бичлэг, техникийн болон холбогдох бусад өгөгдлийг багтаасан бүх бүртгэлийг тухайн осол, эсхүл зөрчил болсноос хойш 14 хоногоос доошгүй хугацаагаар битүүмжлэн хадгалах үүрэгтэй.

(1) ИНД-171 - байгууламжийн доголдлын зөрчил, эсхүл осол; эсхүл

(2) ИНД-172 - агаарын зайн зөрчил, эсхүл осол; эсхүл

(3) ИНД-173, ИНД-175 - түгээгдсэн мэдээллийн зөрчил, эсхүл осол;

